

МОНГОЛ ОРНЫ ГАЗАР ТАРИАЛАН-  
ГИЙН ТӨВ БҮСИЙН АГРО УУР  
АМЬСГАЛЫН НӨӨЦ

Д.Аззаяа.

*Оришил*

Манай орны газар тариалангийн төв бүсэд Л.Товуугийн ангилаар Булган, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Төв аймаг, Улаанбаатар хотын нутаг багтдаг. [4] Тус бүс уур амьсгалын чийглэгдүү-сэргүүн, хуурайдуу-сэргүүтэр мужид багтдаг. Харин агро уур амьсгалын чийглэг-сэргүүн, чийглэгдүү-сэргүүн, хуурайдуу-сэргүүн, хуурай-сэргүүн мужид [1] харьяалагдана.

*Судалгааны арга зүй*

Цаг уур, хөдөө аж ахуйн цаг уурын ажиглалтын, уур амьсгалын болон агро уур амьсгалын боловсруулалтын аргуудыг хэрэглэсэн болно.

*Судалгааны ур дун*

Энэ бүс нутагт олон жилийн дунджаар жилд 2738 цаг нар гийгүүлдэг. Нийтмэл цацраг  $3900 \text{ МДж}/\text{м}^2$  жил, шулуун цацраг  $2636 \text{ МДж}/\text{м}^2$  жил, сарнисан цацраг  $1265 \text{ МДж}/\text{м}^2$  жил, ойсон цацраг  $1948 \text{ МДж}/\text{м}^2$  жил байдаг.


Агаарын жилийн дундаж температур  $0.5^\circ\text{C}$  ба хамгийн хүйтэн үе болох 1 дүгээр сарын агаарын дундаж

тэмператур  $-21.0^{\circ}\text{C}$ , хамгийн дулаан үе болох 7 дугаар сарын агаарын дундаж температур  $18.3^{\circ}\text{C}$  байна. Агаарын үнэмлэхүй их температур  $41.0^{\circ}\text{C}$  (Хутаг), агаарын үнэмлэхүй бага температур  $-47.1^{\circ}\text{C}$  (Ерөө) хүрдэг ба агаарын температурын жилийн агууриг  $87.1^{\circ}\text{C}$  байна.

Агаарын дундаж температур 4 дүгээр сарын 3 дугаар арав хоногийн эхний хагаст (24.IV)  $5^{\circ}\text{C}$  дайрч тогтвортой дулаардаг бөгөөд энэ нь 165 хоног үргэлжлэн  $5^{\circ}\text{C}$  ээшихи идэвхтэй температурын нийлбэр  $2322.6^{\circ}\text{C}$ , ашигтай температурын нийлбэр  $1496.1^{\circ}\text{C}$  байдаг. Агаарын дундаж температур 10 дугаар сарын эхний арав хоногт (6.X)  $5^{\circ}\text{C}$  дайрч тогтвортой хүйтээрч эхэлдэг юм.

Агаарын дундаж температур 5 дугаар сарын эхний арав хоногт (8.V)  $10^{\circ}\text{C}$  дайрч тогтвортой дулаардаг ба энэ үе дунджаар 128 хоног үргэлжилж  $10^{\circ}\text{C}$  дээшихи идэвхтэй температурын нийлбэр  $2035.1^{\circ}\text{C}$ , ашигтай температурын нийлбэр  $756.0^{\circ}\text{C}$  (1 дүгээр зураг) хүрдэг байна. Энэхүү зургийн 1 дүгээр арав хоногт 5 дугаар сарын эхний арав хоног харгалзана.

1 дүгээр зураг. ИДЭВХТЭЙ, АШИГТАЙ ТЕМПЕРАТУРЫН НИЙЛБЭР



Есдүгээр сарын 2 дугаар арав хоногт (13.IX) агаарын дундаж температур  $10^{\circ}\text{C}$  дайрах тогтвортой шилжилт ажиглагддаг.

6 дугаар сарын эхээр агаарын дундаж температур  $15^{\circ}\text{C}$  дайрч дулаардаг ба энэ үе дунджаар 82 хоног үргэлжилж  $15^{\circ}\text{C}$  дээши идэвхтэй температурын нийлбэр  $1456.9^{\circ}\text{C}$ , ашигтай температурын нийлбэр  $225.6^{\circ}\text{C}$  байдаг. Агаарын дундаж температур  $15^{\circ}\text{C}$  дайрах тогтвортой шилжилт 8 дугаар сарын 3 арав хоногт (24.VIII) гол төлөв ажиглагдана.

Хөрсний гадаргын үнэмлэхүй их температур  $69.5^{\circ}\text{C}$  (Зүүнбүрэн, Хүдэр), хөрсний гадаргын үнэмлэхүй бага температур  $-54.3^{\circ}\text{C}$ , (Алтанбулаг, Сэлэнгэ) ажиглагдаж хөрсний гадаргын температурын жилийн агууриг  $123.8^{\circ}\text{C}$  -д хүрчээ.

Жилд дунджаар 260 мм хур тунадас унадаг ба түүний 90% буюу 234 мм дулааны улирлын 4-9 дүгээр сар оногддог.

Агаарын жилийн дундаж харьцангуй чийгшил 63% байдаг ч хаврын улиралд (IV-V сард) ихэвчлэн 35-50% болтол буурдаг.

Баруун хойд зүгийн салхи зонхилох бөгөөд жилийн дундаж хурд 2.1 м/с байдаг. Жилийн 53.6% нь салхигүй намуун байдаг.

Хаврын эцсийн цочир хүйтрэлт 5 дугаар сарын дугаар арав хоногт (22.V), намрын эхний цочир хүйтрэлт дүгээр сарын 2 дугаар арав хоногт (11.IX) гол төлөв ажиглагддаг бөгөөд хүйтрэлгүй хугацаа дунджаар 111 хоног үргэлжилнэ. Гэхдээ цочир хүйтрэлт 6, 7 дугаар сард (1987.VII.02, Дархан-Уул аймаг) ажиглагддаг билээ.

Хөрсний 20 см-ын гүнд  $8^{\circ}\text{C}$  ба түүнээс дээш хэмийн температуртай, чийг нь бүрэн чийг багтаамжийн 14-16% тай тэнцэх хязгаар дотор байх үед хөрсийг боловсруулахаа тохиromжтой гэж үздэг бөгөөд үүнийг хөрсний физик бол гэнэ.[3]

Энэ бүсийн хувьд дээрх шилжилт ихэвчлэн 4 дүгээр сарын 3 дугаар арав хоногт тохиолддог тул хөр

боловсруулах ажлыг 4 дүгээр сарын 25-наас эхлэн хийх боломжтой болдог.

Үр тарианы ургамлын үрийг гол төлөв 7-8 см, тэмсийг 15-20 см-ын гүнд суулгадаг билээ. [5].

5 дугаар сарын эхний хагаст хөрсний 10 см-ын гүнд  $10^{\circ}\text{C}$ -ийг дайрч тогтвортой дулаардаг тул 5 дугаар сарын 5-наас 15-ны хооронд зарим таримал ургамлыг тариалах боломжтой юм.

Хөрс боловсруулалт, тариалаалтын үед тус бүсийн ихэнх нутагт баруун, баруун хойд зүгийн салхи зонхилно.

Салхины дундаж хурдны хоногийн явцыг авч үзэхэд шөнийн хугацаанд салхины хүч бага, өдрийн хугацаанд салхины хүч ихсэх хандлагатай юм. (1 дүгээр хүснэгт)

### 1 дүгээр хүснэгт

#### САЛХИНЫ ДУНДАЖ ХУРД, М/С

сар, цаг	23	02	05	08	11	14	17	20
1	1.2	1.2	1.2	1.4	3.2	1.9	1.4	1.3
2	1.2	1.3	1.3	1.4	1.6	2.4	2.0	1.4
3	1.5	1.6	1.7	1.7	2.5	3.6	3.5	1.9
4	2.2	2.2	2.3	2.6	3.9	4.8	4.7	3.0
5	2.1	2.1	1.9	2.4	3.5	4.5	4.3	3.2
6	1.8	1.7	1.5	2.1	2.8	3.5	3.4	2.8
7	1.4	1.3	1.2	1.6	2.2	2.8	2.8	2.2
8	1.3	1.3	1.2	1.5	2.0	2.8	2.7	1.9
9	1.4	1.5	1.4	1.5	2.3	3.1	2.9	1.8
10	1.4	1.4	1.4	1.5	2.2	3.2	2.8	1.6
11	1.3	1.4	1.4	1.5	1.8	2.7	1.9	1.5
12	1.2	1.4	1.4	1.5	1.4	2.0	1.4	1.3

Хөрс боловсруулах, тариалах үеийн салхины дундаж хурдны хоногийн явцыг 2 дугаар зурагт үзүүллээ.

**2 дутаар зураг. САЛХИНЫ ХУРДНЫ  
ХОНГОЙН ЯВЦ, М/С**



Зургаас хараад өглөөний 08 цагаас эхлэн салхины хүч нэмэгдсээр өдрийн 14 цагт бараг 2 дахин их хүчтэй болж аажим буурсаар шөнийн 23 цагт өглөөний 08 цагийн түвшинд хүрч буурдаг байна. Өдрийн хугацаанд салхины хүч ихсэж байгаа нь дээрх ажлуудыг гүйцэтгэхэд тодорхой бэрхшээл учруулахын зэрэгцээ хагалсан хөрсний ялзмал ўе давхарга ямар нэгэн хэмжээгээр алдагдаж болзошгүй юм.

*Дүгнэлт*

Хөрс боловсруулах, тариа, ногоо тариалах ажлуудыг гүйцэтгэхдээ тухайн нутгийн агро уур амьсгалын нөөц болон салхины чиглэл, хурдыг тооцох шаардлага зайлшгүй гарч байна.

*Abstract*

In this paper, we made an attempt to study agroclimatic resource of the Central agricultural region of Mongolia as well as the optimal period for soil cultivation, sowing and wind regime. During the above period the main wind direction is west

and north-west. The optimal period for soil cultivation is from 25 April to 5 May, for sowing is from 5 to 15 May.

### АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. БНМАУ-ын уур амьсгал, гадаргын усны нөөцийн атлас, УБ, 1985.
2. Кельчёвская.Л.С, Методы обработки наблюдений в агрометеорологии, Л, Гидрометеоиздат, 1971.
3. Синицина.Н.И, Гольцберг.И.А, Струнников.Э.А, Агроклиматология, Л, Гидрометеоиздат, 1973.
4. Товуу. Л, Газар тариалан, УБ, 1980.
5. Chang. Jen-hu, Climate & Agriculture an ecological survey, Chicago, 1969.
6. Mavi.H.S, Indroduction to Agro-meteorology, New Delhi, 1994.
7. Martin Parry, Climate change & world agriculture, London, 1990.